



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

\_\_\_ оны \_\_\_ сарын \_\_\_ өдөр

Дугаар A/156

Булган


**Хөрөнгө гаргах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4.в, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 7.6.2, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3 дахь заалт, аймгийн ИТХ-ын 2018 оны 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотоос Дархан-Уул аймаг чиглэлийн олон улсын чанартай авто замыг түр хугацаагаар хааж, Булган, Орхон, Хөвсгөл аймгаас Улаанбаатар хот чиглэлийн зорчигч тээврийн хэрэгслэлүүд Булган аймгийн сумдаар дайран өнгөрөхөөр маршрут гарсантай холбогдуулан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хангах, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий мэдээлэх самбар байршуулсугай.

2. Шаардагдах 8 000 000 /найман сая/ төгрөгийг Авто замын сангийн хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Д.Батцогт/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

20190186